



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх  
стандартыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 27 дугаар зүйлийн 27.3.1, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага”-ыг гуравдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тус стандартуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан /Т.Итгэл/, их эмч /Н.Энхзаяа/, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын инженер /Б.Доржбалжир/ нарт даалгасугай.

3. Стандартуудын хэрэгжилтийг ханган, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Х ЭРДЭНЭБИЛЭГ

1150500035